

Цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаанд баримтлах цацрагийн удирдлагын хөтөлбөр боловсруулах зөвлөмж

1 Оршил

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цөмийн энергийн тухай хууль, Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, стандартууд, цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах, хагядлын менежмент хийх, хаах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд мөрдөх дүрэм болон холбогдох бусад журам, стандартад заасан шаардлагуудыг хэрэгжүүлэхийн тулд байгууллагын үйл ажиллагааны үндсэн асуудлыг Цацрагийн удирдлагын хөтөлбөрт (ЦУТ) тусгавал зохино. Цацрагийн удирдлагын хөтөлбөр нь байгууламжийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдамжийн үүрэг гүйцэтгэнэ. Тиймээс энхүү зөвлөмж нь учраас энэ нь цацраг идэвхт материалтай ажилладаг буюу ионжуулагч цацрагийн шарлагад өртдөг ажилчид, хүн амын цацрагийн аюулгүй байдал болон байгаль орчны цацрагийн асуудлыг хариуцдаг бүхий л ажилтанд хамааралтай бие даасан баримт бичиг юм.

Аюулгүй ажиллагааны хөтөлбөр нь аюулгүй ажиллагааны үнэлгээний үр дүнгийн хураангуй бөгөөд тус үнэлгээ нь *юуны өмнө* цацрагийн аюулгүй ажиллагааны хувьд цацрагийн удирдлагын хөтөлбөрийн заалтууд хангалттай хэрэгжиж байгаа эсэхийг үнэлэх буюу ашиглалт эхлэхээс өмнө тусгай зөвшөөрөл эзэмшигч цацрагийн удирдлагын хөтөлбөрт хэр нийцэж байгааг үнэлнэ. Тиймээс цацрагийн удирдлагын хөтөлбөр нь аюулгүй ажиллагааны хөтөлбөртэй нийцэж байх нь чухал юм.

2 Цацрагийн удирдлагын хөтөлбөрт тусгах элементүүд

Цацрагийн удирдлагын хөтөлбөрт тухайн олборлох, боловсруулах үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлага, нөхцөлүүдэд тохируулан тусгах хамгийн наад захын асуудлуудыг дараах хүснэгтэд оруулав.

| Цацрагийн удирдлагын хөтөлбөрт тусгах үндсэн бүлгүүд | Агуулгын талаарх удирдамж (жишээнүүд) |
|--|--|
| Хамрах хүрээ ба зорилго | <ul style="list-style-type: none">• <u>Хамрах хүрээ:</u> Энэхүү Цацрагийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууламжийн бүх үйл ажиллагаа, чухал үзүүлэлт, асуудлуудыг жагсаах.• <u>Зорилго:</u> Цацрагийн удирдлагын хөтөлбөрийн зорилго нь шарлагад өртөх хамгийн гол замыг тогтоож, олборлох, боловсруулах болон бусад үйл ажиллагаанаас улмаас авах мэргэжлийн шарлагын тун, хүн амын шарлагын тун, хэвийн нөхцлийн шарлагын тун, болзошгүй буюу санамсаргүй цацрагийн ослын шарлагыг тунг хязгаарлахын тулд авч хэрэгжүүлэх удирдлагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, дэг журмыг тогтооход оршино. Цацрагийн удирдлагын хөтөлбөр нь уурхай, боловсруулах үйлдвэр болон бусад |

| | |
|--|---|
| | <p>байгууламжийн ашиглалт ба хаалтын явцад үүсэх ионжуулагч цацрагийн шарлагаас ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид болон хүн амын авах цацрагийн тунгийн хэмжээг багасгаж, зохицуулахтай холбоотой заавар журам, үйл ажиллагааг тодорхойлно.</p> |
| <p>Байгууламжийн тодорхойлолт</p> | <p>Ерөнхий мэдээлэл:</p> <ul style="list-style-type: none"> • Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төв байр болон олборлох, боловсруулах үйл ажиллагааны ажлын талбай дээрх холбоо барих хүмүүсийн нэр, хаяг • Уурхай, боловсруулах үйлдвэр болон бусад байгууламжийн товч тодорхойлолт, үүний дотор үндсэн болон нэмэлт ажиллагааны байгууламж. • Газрын зураг, ерөнхий бүдүүвч зураг зэрэг нэмэлт баримт бичгийг гаргаж өгвөл зохино. <p>Ажиллах хүчний тухай мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> • Ажлын категори, ажиллагчдын хүйс, төрөл (компаний эсвэл гэрээт гүйцэтгэгчийн) • Ашиглагдаж буй ээлж/бүрэлдэхүүний систем • Жилийн дундаж ажлын цаг <p>Төлөөлөх ажилтнуудын мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> • Уурхай, боловсруулах үйлдвэр болон бусад байгууламжийн ашиглалт/хаалтын нөлөөлөлд өртөж болох хүн амын бүлгийн хэмжээ ба байршил • Төлөөлөгчдийн тодорхойлолт • Байршил (газрын зургууд) • Хэрэглээний онцлог, ундны ус, хүнсний бүтээгдэхүүний эх үүсгүүр |
| <p>Холбогдох удирдлагын бусад хөтөлбөр, удирдлагын тогтолцооны бусад элемент</p> | <p>Удирдлагын тогтолцооны бүх элемент, цацрагийн удирдлагын хөтөлбөртэй холбоотой бусад гол гол удирдлагын төлөвлөгөө, ижил төстэй баримт бичгүүдийн жагсаалт. Эдгээрээс жишээ болгон дурдвал:</p> <ul style="list-style-type: none"> • Цацраг идэвхт хаягдлын менежментийн төлөвлөгөө • Ослын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө • Хаах ба нөхөн сэргээх төлөвлөгөө |
| <p>Тусгай зөвшөөрөл</p> | <ul style="list-style-type: none"> • Зохион байгуулалтын бүдүүвч |

| | |
|---|---|
| <p>Эзэмшигч байгууллага</p> | <ul style="list-style-type: none"> • Цацрагийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд онцгойлон хамаарах үүрэг, хариуцлага |
| <p>Хүний ба бусад нөөц</p> | <p>Цацрагийн хамгаалалтын чиглэлээр зохих мэргэжлийн боловсон хүчинтэй бөгөөд гаднаас мэргэжлийн туслалцаа авах боломжтой болохоо харуулах, жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Удирдлагын чиг үүрэг, гүйцэтгэх үүрэг • Цацрагийн хамгаалалтын ажилтны байгууллага дотроо гүйцэтгэх үүрэг, чиг үүрэг (ЦХА, цацрагийн хамгаалалтын туслах ажилтан) • Холбогдох бусад албан тушаал, тэдгээрийн тусгай чиг үүрэг (байгаль орчны менежер, орон нутагтай харилцах менежер) • Зохих техникийн мэргэжлийн туслалцаа авах боломж (лаборатори, гадны шинжээч, хяналтын гэрээт гүйцэтгэгч) <p>Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зохион байгуулалтын бүдүүвчийг эшлэн заавал зохино.</p> <p>Цацрагийн аюулгүй ажиллагааны удирдамж RS-G-1.6 -ийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах чиглэлээр мэргэшсэн шинжээчдийг ажилтнаар буюу гэрээт гүйцэтгэгчээр авч ажиллуулбал зохино:</p> <ul style="list-style-type: none"> • Цацрагийн хамгаалалт ба тунгийн хэмжилт • Агааржуулалт (шаардлагатай үед, тухайлбал далд уурхайд) • Мэргэжлээс шалтгаалах өвчин • Үйлдвэрийн аюулгүй ажиллагаа <p>Цацрагийн хамгаалалтын ажилтан болон түүний туслахын ажлын байрны чиг үүргийн дэлгэрэнгүй тодорхойлолт</p> |
| <p>Үйл ажиллагаа ба шарлагын эх үүсгүүр</p> | <p>Ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид буюу хүн амыг ионжуулагч цацрагийн шарлагад өртүүлж болзошгүй, байгууламж дээр явагддаг үйл ажиллагааны жагсаалт</p> <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа • Байрлал • Шарлагын төрөл/шарлагын үндсэн зам <p><u>Төрлүүд эсвэл шарлага:</u></p> |

| | |
|--|---|
| | <p>Ажилчдын шарлага (түгээмэл жишээ)</p> <ul style="list-style-type: none"> • Шууд цацраг • Тоос • Радон • Гадарга нь бохирдсон зүйлстэй харьцах <p>Хүн амын шарлага (түгээмэл жишээ)</p> <ul style="list-style-type: none"> • Ус ашиглах (Гүний ба гадаргын ус) • Хүнсний бүтээгдэхүүн • Тоос • Радон |
| <p>Тунгийн зөвшөөрөгдөх хязгаар ба тогтоосон хязгаарлалт</p> | <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн шарлагын тунгийн зөвшөөрөгдөх хязгаар • Жирэмсэн ба залуу ажилчдад зориулсан заалтууд • Хүн амын шарлагын тунгийн зөвшөөрөгдөх хязгаар ба тогтоосон хязгаарлалт |
| <p>Цацрагийн хяналтын арга хэмжээ</p> | <p>Шарлагын хяналтын шатлалыг тусгах</p> <ul style="list-style-type: none"> • Анхдагч хяналт • Хоёрдогч хяналт <p>Жишээнүүдээс дурдвал:</p> <p>Гамма тунгийн чадал</p> <ul style="list-style-type: none"> • Анхдагч: Өндөр тунтай бүсэд ажиллах хугацааг хязгаарлах, өндөр тунтай бүсээс ажиллагчдыг шилжүүлэх • Хоёрдогч: Хаалт хэрэглэх, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах <p>Радон</p> <ul style="list-style-type: none"> • Анхдагч: Агааржуулалт, ажиллагчдыг хязгаарлах • Хоёрдогч: Ажилтнуудыг сэлгэн ажиллуулах <p>Тоос</p> <ul style="list-style-type: none"> • Анхдагч: Тоосыг дарах • Хоёрдогч: Хувийн хамгаалах хэрэгсэл <p><u>Ажлын бүсчлэл, ажлын зохион байгуулалт, эрүүл ахуй, түгээмэл жишээнүүдээс дурдвал</u></p> <ul style="list-style-type: none"> • Хяналтын бүс (жишээ нь: далд уурхай, боловсруулах үйлдвэр, концентрацийн агуулах г.м) • Ажиглалтын бүс (жишээ нь: хаягдал чулуулгын овоолго, уурхайн хаягдлын менежментийн байгууламж) |

| | |
|--|--|
| | <ul style="list-style-type: none"> • Ерөнхий ажлын бүс (дээрхээс бусад бүгд) • Хяналтын болон ажиглалтын бүсүүдийг тусгаарлах (жишээ нь: анхааруулах тэмдэг, орох гарах хаалга, нэвтрэх хяналт) • Мэргэжлийн шарлагад өртдөг ажилтнуудыг авч буй цацрагийн шарлагын түвшнээр нь ангилах¹ • Ажлын байрны хяналт/хувийн тунгийн хяналт • Хяналтын болон ажиглалтын бүсэд ажиллах хүмүүсийн эрүүл мэндийг хянах, мэргэжлийн шарлагад өртдөг ажилчдыг мэргэжлээс шалтгаалах өвчний эмнэлгийн үзлэгт тогтмол хамруулах (доорх “ажилчдын эрүүл мэндийн тандалт судалгаа” хэсгийг үзнэ үү) • Хяналтын болон ажиглалтын бүсүүдэд байх хугацаа (шаардлагатай бол хугацааны хязгаар) • Хяналтын болон ажиглалтын бүсүүдэд идэж, ууж, тамхи татахыг хориглох • Ажлын заавар, дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах хяналтын болон аудитын хөтөлбөр <p><u>Инженер, техникийн шийдэл. Түгээмэл жишээнүүдээс дурдвал</u></p> <ul style="list-style-type: none"> • Хязгаарлан хянах байгууламж • Цацрагийн үүсгүүр хүртэлх зай <p><u>Цацраг идэвхт материал хяналтгүй тархахаас сэргийлэх. Түгээмэл жишээнүүдээс дурдвал</u></p> <ul style="list-style-type: none"> • Ачааны машин болон хүнд машин механизмыг угаах, бохирдлыг нь арилгах • Тоосноос сэргийлэх (хуурай материалыг чийглэх) • Ахуйн ерөнхий цэвэрлэгээ үйлчилгээ <p><u>Гэрээт гүйцэтгэгчийн удирдлага</u></p> <ul style="list-style-type: none"> • Зохион байгуулалтаар хангах заалтууд • Гэрээт гүйцэтгэгчдийг аудитад хамруулах • Жич: гэрээт гүйцэтгэгчдийн хэрэглэдэг дүрэм, удирдамж тусгай зөвшөөрөл эзэмшигчийнхээс илүү чанга биш бол тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн дүрэм, удирдамжийг сахиулан мөрдүүлэх үүрэг хариуцлагыг хүлээнэ |
|--|--|

¹Жишээ нь: хэрэв ЕХ-ны Аюулгүй ажиллагааны үндсэн стандартын категориуд хэрэглэж байгаа бол А буюу В категори

| | |
|---|--|
| Хяналт | <p>Тус хэсэгт дараах зүйлсийг товчхон дурдана (Хяналтын төлөвлөгөөг давтахгүйгээр)</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн шарлагын хяналтын хөтөлбөр • Хүрээлэн буй орчны хяналтын хөтөлбөр • Ашиглалтын (явцын) хяналтын хөтөлбөр <p>Дараах асуудлыг тусгах:</p> <ul style="list-style-type: none"> • Хяналтын сүлжээ, үзүүлэлт, байршил, давтамж (Хяналтын төлөвлөгөөг эшлэн заавал зохино) • Шалган тогтоох түвшин • Тунг тооцохын тулд бус харин цэвэрлэгээний чанарыг үнэлэхийн тулд явуулах гадаргын бохирдлын шалгалт <p>Хяналт ба түүнд ашиглах дозиметрийн хэмжилтийн багажууд</p> <ul style="list-style-type: none"> • Байршил (буюу хувийн багаж) • Байнгын/нэгтгэх буюу давтамж • Хэмжиж буй цацрагтай холбоотой үзүүлэлтүүд |
| Цацрагийн шарлагатай холбоотой тохиолдол, осол гамшиг | Ослын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг эшлэн заавал зохино |
| Сургалт/боловсрол, мэдлэг олгох | <p>Сургалтын хөтөлбөрт дараах элементүүдийг тусгана:</p> <ul style="list-style-type: none"> • Бүх ажилчдад зориулсан цацрагийн аюулгүй ажиллагаатай холбоотой тусгай агуулга бүхий танилцуулах сургалт • Тухайн ажлын байранд тавигдах цацрагийн аюулгүй ажиллагааны тусгай сургалт • Давтан сургалт • Зочдод зориулсан аюулгүйн зааварчилгаа/танилцуулах сургалт • Гадны ажилчдад сургалт, боловсролын шаардлагыг сахиулан мөрдүүлэх <p>Аюулгүйн зааварчилгаа ба сургалтын агуулга (жишээ)</p> <ul style="list-style-type: none"> • Цацраг ба цацрагийн аюулгүй ажиллагааны үндэс • Цацрагийн төрөл, цацрагийн үүсгүүр, тэдгээрийн хэрэглээ • Цацрагийн тун ба тунгийн хязгаарын ойлголт • Хүний биед цацрагийн үзүүлэх нөлөөллийн |

| | |
|---|--|
| | <p>үндэс</p> <ul style="list-style-type: none"> • Шарлагын үндсэн замууд • Цацрагтай холбоотой аюулыг хэрхэн зохицуулах тухай • Хувь хүн өөрийн өртөх цацрагийн шарлагийг хэрхэн хязгаарлаж болох тухай • Эрүүл ахуйн үндсэн заавар, шаардлагууд • Өмсөх буюу зүүх шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслүүд • Байгууламж дээр шарлагыг хэрхэн хянаж, зохицуулдгийг харуулсан зураг <p>Сургалт ба аюулгүйн зааварчилгаа хичээл нь ерөнхий эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанаас гадна цацрагийн хамгаалалтын сэдвийг хамарвал зохино. Ажлын байрны аюулгүй ажиллагааны хуралдаанд цацрагийн аюулгүй ажиллагаатай холбоотой элементүүдийг оруулах хэрэгтэй.</p> <p>Илүү төрөлжсөн сургалтад сорьцлолт болон хэмжилт хяналтын хэрэгсэл ажиллуулах зэрэг тусгай чиглэлээр мэргэжсэн ажилтнуудыг хамруулах нь зүйтэй.</p> |
| <p>Эрүүл мэндийн тандалт, тунг үнэлэх</p> | <p><u>Ажилчдын эрүүл мэндийн тандалтын бүртгэл</u></p> <ul style="list-style-type: none"> • Бүх ажилчны нэрс • Ажил үүргээ гүйцэтгэж эхэлсэн огноо • Тухайн ажилчин урьд нь ионжуулагч цацрагийн шарлагад өртөж болох хөдөлмөр эрхэлж байсан бол түүний өмнөх хөдөлмөр эрхлэлтийн байдлын бүртгэл • Ажилд орохын өмнөх эмнэлгийн үзлэгийг хийсэн эмчийн нэр, хаяг • Үнэлгээ, үүний дотор цээжний рентген зураг, тухайн ажилтан/гэрээт гүйцэтгэгчийн эрүүл мэндийн бүртгэл мэдээллийг хэн хадгалдаг • Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эхлүүлсэн буюу шаардсан эмнэлгийн үзлэг шинжилгээний огноо, эмчийн нэр, хаяг • Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал • Цацрагтай холбоотой сургалт, хичээл, мэдлэг дээшлүүлэх дасгал, эрсдэл, аюулын тухай шинэ мэдээллийн танилцуулга болон бусад ижил төстэй үйл ажиллагаанд оролцсон тухай бүртгэл <p>Тунгийн тооцооны хувьд дараах мэдээллийг баримтжуулах хэрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> • Ажилчид болон хүн амын шарлагад өртөх зам тус бүртэй холбоотой цацраг идэвхт |

| | |
|-------------------------------------|--|
| | <p>нуклид</p> <ul style="list-style-type: none"> • Тун тооцоолох арга, алгоритм, төсөөлөл • Хөрвүүлэх коэффициент (тоос, Rn, ус, хоол хүнсний зам) • Шарлагын нөхцөл байдал • Амьдрал ба ажлын хэвшил (гадаа ба дотор өнгөрүүлдэг хугацаа, ажлын байран дээр өнгөрүүлдэг хугацаа) • Хэрэглээний хэмжээ ба амьсгалах хурд <p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тун тооцоолох удирдамж хэрэглэхийг зөвлөж байна (жишээ нь: ВМУ 99) Хэрэв янз бүрийн замаар цацраг идэвхт бодис зөөгддөг талаар ямар ч мэдээлэл байхгүй бол, нуклид болон замын холбогдлын анхны судалгааг ОУАЭА-ийн Аюулгүй ажиллагааны тайлан 19 (ерөнхий загварууд) ашиглан явуулж болно.</p> |
| Тайлан ба бүртгэл хөтлөлт хадгалалт | <p>Дүрэм журмыг дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах шалгалтын үр дүнг эрх бүхий байгууллагад тохиромжтой форматаар тогтмол мэдээлж байвал зохино.</p> <p>Эрүүл мэндийн тандалтын бүртгэлийн мэдээллийг Цацрагийн хамгаалалтын ажилтан удирдаж, нууцлалыг нь чандлан хадгална.</p> <p>Монгол Улсын хууль эрх зүйн шаардлага, Аюулгүй ажиллагааны үндсэн стандартыг эшлэн заавал зохино.</p> |
| Чанарын баталгаа | <ul style="list-style-type: none"> • Хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тохируулга (дозиметр, гамма-спектрометр зэрэг лабораторийн шинжилгээний багаж, гадаргын бохирдол хэмжигч, зөөврийн гамма хэмжүүр, радоны монитор зэрэг талбай дээр хэмжилт хийх багаж хэрэгслүүд) • Аудитын талаарх заалтууд (дотоод ба хөндлөнгийн) • ISO 900X стандартын ерөнхий зарчмуудыг харгалзан үзвэл зохино • Гэрээт гүйцэтгэгч болон гадны ажилчид тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цацрагийн менежменттэй бүрэн нийцэж байгаа эсэхийг нягтлах заалтууд |
| Аюулгүй байдал | <p>Зохион байгуулалтын зохицуулалт, жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> • Аюулгүй байдлын менежмент • Нэвтрэх хяналт • Камерын хяналт |

| | |
|-------------------------------|---|
| | <p>Биет хамгаалалт</p> <ul style="list-style-type: none"> • Барилга байгууламж • Түгжээ бүхий хаалганууд • Хашаа <p>Хамгаалалтын системийн хүний нөөц</p> <ul style="list-style-type: none"> • Зэвсэгтэй • Зэвсэггүй • Цагдаагийн хүчийг ашиглах |
| Төлөвлөгөөг хянах ба шинэчлэх | <p>Цацрагийн удирдлагын хөтөлбөрийг хянах ба шинэчлэхэд цаг үеэсээ хоцрохгүй, тасралтгүй сайжруулах явцыг хангана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хяналт/шинэчлэлийн хугацааны давтамж • Байгууллагын доторх үүрэг хариуцлага • Хөндлөнгийн хяналт • Энэ төлөвлөгөөний заалтуудыг дагаж мөрдөж байгаа эсэхийг нягтлах аудит |

3 Лавлах материал

Олборлолт ба эрдэс боловсруулалтын явцад байгалийн гаралтай цацраг идэвхт материалыг (NORM) зохицуулах – NORM-2.2 тоот удирдамж “Цацрагийн удирдлагын төлөвлөгөө бэлтгэх - олборлолт ба боловсруулалт”. Нөөцийн салбарын аюулгүй ажиллагаа, Уул уурхай, газрын тосны департамент, Баруун Австрали (2010)

Олборлолт ба эрдэс боловсруулалтын үеийн цацрагийн хамгаалалт, цацраг идэвхт хаягдлын менежмент. Цацрагийн хамгаалалтын цуврал № 9, Австралийн Засгийн газар, Австралийн цацрагийн хамгаалалт ба цөмийн аюулгүй ажиллагааны агентлаг (2005)

Цацраг идэвхт бодис байгаль орчинд ялгаруулахад үзүүлдэг нөлөөллийг үнэлэхэд хэрэглэдэг ерөнхий загварууд. Аюулгүй ажиллагааны тайлангийн цуврал, № 19, Вена: Олон улсын атомын энергийн агентлаг (2001)

ВМУ-99 Тооцооллын удирдамж. Уул уурхай: Олборлолттой холбоотой хүрээлэн буй орчны цацраг идэвхийн улмаас авах цацрагийн шарлагын хэмжээг тооцоолох удирдамж. Цацрагийн хамгаалалт ба байгаль орчны хэлтэс, Германы Холбооны Засгийн газрын цацрагийн хамгаалалтын газар, Залцгиттер 1999 (2011 оны 9-р сард шинэчлэгдсэн)